



**МОНГОЛ УЛС**  
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**  
**ТОГТООЛ**

2010 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 416

Улаанбаатар хот

Г “Монгол траст холдинг даатгал” ХХК-д дүрмийн 7  
сангийн хэмжээ, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүндээ  
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21.3.2, 21.5, 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 153 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монгол траст холдинг даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг нэг бүр нь 1000.0 /нэг мянган/ төгрөгийн үнэ бүхий 500 000 ширхэг хувьцаа буюу нийт 500 000 000.0 /таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

№	Хувь нийлүүлэгчид	Дүрмийн сангийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	“Вектор интернэйшнл” ХХК	500 000 000.0	-	500 000 000.0	50,0%
2	Амаржаргал овогтой Гансүх	-	500 000 000.0	500 000 000.0	50,0%
	Нийт	500 000 000.0	500 000 000.0	1 000 000 000.0	100,0%

2. Дүрмийн сангийн хэмжээ болон хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2011 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Монгол траст холдинг даатгал” ХХК /Г.Баттогтох/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН